



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

**Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын ээлжит II хуралдаан зарлан хуралдуулах  
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.2, 23.4 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит II хуралдааныг 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 09 цагт зарлан хуралдуулсугай.
2. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг нэгдүгээр, бэлтгэл ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, шаардах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралдааныг бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, зардлыг хурлын зохих төсвөөс гарган, хуралдаанаас гарах шийдвэрийг холбогдох газруудад хүргүүлэн ажиллахыг Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Ж.Ичинноров/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Г.БАТСАЙХАН

Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 11 дүгээр  
сарын <sup>27</sup>...-ны өдрийн <sup>49</sup>... дугаар тогтоолын  
нэгдүгээр хавсралт



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИТХ-ЫН ЭЭЛЖИТ II ХУРАЛДААНААР  
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Дүүргийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2020 оны биелэлт, дүүргийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан

2. Дүүргийн 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2021 оны төлөвлөгөөний тухай

Дүүргийн Газар зохион байгуулалтын  
албаны дарга Б.Батчимэг

3. Дүүргийн 2019 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай

4. Дүүргийн 2020 оны төсвийн нэмэлт өөрчлөлт хийх тухай

5. Дүүргийн 2021 оны төсвийн төслийг батлах тухай

Дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан

6. Хурлын хороод байгуулах тухай

Дүүргийн ИТХ-ын дарга Г.Батсайхан

--ooOoo--